



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах сургууль,
дадлага зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2, 13.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 51 дүгээр зүйлийн 51.4, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 198 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд нийслэлийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээд, томилгоот бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдал, хамтын ажиллагааг сайжруулах, хүн, техник хэрэгслийг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор нийслэлийн хэмжээнд 2019 онд зохион байгуулах гамшгаас хамгаалах сургууль, дадлагын хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

2. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Нийслэлийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, удирдах бүрэлдэхүүний сургалтад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах чиглэлээр зохион байгуулах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэгийг мэргэжлийн удирдлагаар ханган, цаг хугацаанд нь зохион байгуулж, дүнг танилцуулахыг Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН
БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
01 сарын 17-ны өдрийн
А/Засаг захиралт

ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ, ДАДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Байгууллагын нэр	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хяналт тавих байгууллага
Нэг. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль				
1	Багахангай дүүрэг	2019 оны 05 дугаар сар	Засаг дарга С.Эрдэнэбаяр	Нийслэлийн Онцгой байдлын газар
2	Хан-Уул дүүрэг	2019 оны 06 дугаар сар	Засаг дарга Ж.Алдаржавхлан	
3	Баянгол дүүрэг	2019 оны 09 дүгээр сар	Засаг дарга С.Одонтуяа	
Хоёр. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг				
1	Налайх дүүрэг	2019 оны 03 дугаар сар	Засаг дарга Ч.Раднаабазар	Нийслэлийн Онцгой байдлын газар
2	Чингэлтэй дүүрэг	2019 оны 06 дугаар сар	Засаг дарга Ж.Эрдэнэбат	
3	Сүхбаатар дүүрэг	2019 оны 09 дүгээр сар	Засаг дарга Х.Болормаа	
Гурав. Удирдах бүрэлдэхүүний сургалт				
1	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГазар	2019 оны 10 дугаар сар	Дарга Ж.Чинзориг	Нийслэлийн Онцгой байдлын газар
2	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	2019 оны 03 дугаар сар	Дарга Т.Гантөмөр	